

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Нэг. Ерөнхий зүйл
Хэнтий аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор	Аудитын нэр 2
Ц.Энхтүвшин	Аудитын код 2
Аудитын менежер	Аудит хийсэн үндэслэл, хугацаа..... 2
Б.Наранцэцэг	Аудитын зорилт 2
Ахлах аудитор Н.Туяа	Аудитын хамарсан хүрээ..... 2
Аудитор Ү.Төгсжаргал	Үндсэн мэдээлэл 2
	Хоёр. Аудитын дүн, дүгнэлтийн талаар
	2.1 Аймгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн талаар 2
	2.2 Төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар 4
	2.3 Төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар 5
	2.4 Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн талаар 7
	Гурав. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар7
	Дөрөв. Аудитын зөвлөмжийн хэрэгжилт..... 7
	Тав. Дүгнэлт 8
	Зургаа. Аудитын зөвлөмж 8
	Долоо. Холбогдох байгууллагын санал 8
2015 оны 5 дугаар сар	Найм. Хавсралтууд..... 9
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал <u>70562147</u> дугаарын утас, <u>70562112</u> дугаарын факсаар харилцана уу.	1. Хэнтий аймгийн 2014 оны төсвийн орлогын судалгаа
	2. Хэнтий аймгийн ТЕЗ-чийн нэгдсэн зардлын судалгаа
	3. Хэнтий аймгийн тусгай шилжүүлгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн судалгаа
	4. Орон нутгийн 2014 оны төсвийн гүйцэтгэл
ХАЯГ: Хэнтий аймгийн аудитын газар	

Нэг. Ерөнхий зүйл

Аудитын нэр: Хэнтий аймгийн 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Аудитын код: УАГ-ГАГ / 2015 /НТГ- ХЭААГ

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

УАГ-ын нэгдсэн удирдамж, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны 2015 оны төлөвлөгөөний дагуу Орон нутгийн 2014 оны төсвийн гүйцэтгэлд 2015 оны 5 дугаар сарын 01-нээс 13-ныг хүртэлх хугацаанд гүйцэтгэлийн аудитыг ахлах аудитор Н.Туяа, аудитор Ү.Төгсжаргал нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Хэнтий аймгийн 2014 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөлт үндэслэлтэй эсэх болон орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж дүгнэлт гарган, УАГ, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад 2014 оны улсын болон орон нутгийн төсөв, аймгийн ТЕЗ, тусгай шилжүүлгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалыг хамруулсан болно.

Үндсэн мэдээлэл

Монгол улсын 2014 оны төсвийн тухай хуулиар Хэнтий аймгийн орон нутгийн төсвийн орлогыг 6832.4 сая төгрөг, суурь зарлагыг 16507.4 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгт 9675.0 сая төгрөг баталсан байна. Мөн тусгай зориулалтын шилжүүлэгт 30172.1 сая төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэгт 10461.5 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэгээр санхүүжиж буй улсын төсвийн байгууллагын өөрийн орлогыг 95.2 сая төгрөгөөр, орон нутгийн төсвийн нийт орлого, суурь орлогын зөрүү буюу ОНХС-д төвлөрүүлэх орлогыг 128.0 сая төгрөгөөр баталсан байна.

2014 оны 12 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан “Монгол улсын 2014 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар орон нутгийн төсвийн орлогыг 6832.4 сая төгрөг, суурь зарлагыг 16443.0 сая төгрөг, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгт 9610.6 сая төгрөг олгохоор баталж, өөрчлөлт оруулжээ.

Хоёр. Аудитын дүн, дүгнэлтийн талаар

2.1. Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн талаар

Аймгийн ИТХ-ын 2013 оны 12-р сарын 04-ны өдрийн долоодугаар хуралдааны 04 дүгээр тогтоолоор аймгийн төсвийн нийт орлогыг 56607.4 сая төгрөгөөр баталсны дотор орон нутгийн төсвийн орлого 6839.7 сая төгрөг, улсын төсвийн санхүүгийн дэмжлэг 9675.0 сая төгрөг, ОНХС-гийн орлогын шилжүүлэг 11239.1 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 28758.5 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжиж буй байгууллагын өөрийн орлого 95.2 сая төгрөгөөр тус тус батлагджээ.

Төсвийн нийт зарлага 15604.3 сая төгрөг, аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлыг 782.4 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлэг 28853.7 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 11367.0 сая төгрөг, бүгд 56607.4 сая төгрөгөөр батлагдсан байна.

Хэнтий аймаг 2014 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тодотголыг 2 удаа хийсэн байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын 02 дугаар хуралдааны 2014 оны 06 дугаар сарын 16-ны 02 дугаар тогтоолоор аймгийн төсвийн орлогыг өмнөх оны төрийн сангийн дансны үлдэгдэл болох 1538.1 сая төгрөгөөр, ОНХС-гийн үлдэгдэл 172.3 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийг 912.8 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлогыг 18.5 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 130.0 сая төгрөгөөр, ОНХС-гийн орлогын шилжүүлгийг 16.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, татварын орлогыг 30.0 сая төгрөгөөр, улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийг 41.4 сая төгрөгөөр бууруулан, нийт орлогыг 59324.2 сая төгрөгөөр баталж, орлогыг нийт 2716.7 сая төгрөгөөр, зарлагыг мөн тэр хэмжээгээр нэмэгдүүлсэн байна.

Нэмэгдүүлсэн гол гол төсвийн зарлагыг авч үзвэл аймгийн ОНХС-д олгох шилжүүлэгт 1278.4 сая төгрөг, сумдад олгох тусгай зориулалтын шилжүүлэгээр санхүүжих зардалд 931.3 сая төгрөг, төвлөрсөн арга хэмжээний зардалд 261.0 сая төгрөг, аймгийн ИТХ-ын урсгал зардалд 144.0 сая төгрөг, мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний зардалд 84.5 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын урсгал зардалд 25.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ.

2. Аймгийн ИТХ-ын 13 дугаар хуралдааны 2014 оны 12 дугаар сарын 22-ны 03 дугаар тогтоолоор аймгийн төсвийн орлогыг тусгай зориулалтын шилжүүлэг 500.8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлогыг 2.5 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 2.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 794.0 сая төгрөгөөр, улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийг 22.9 сая төгрөгөөр бууруулсан буюу нийт орлогыг 310,8 сая төгрөгөөр бууруулж, 59013,4 сая төгрөгөөр баталсан.

Төсвийн нийт зарлагыг мөн 310,8 сая төгрөгөөр бууруулсны дотор сумдын ОНХС-д олгох шилжүүлгийг 477.4 сая төгрөгөөр, аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг 316.6 сая төгрөг, БОХГ-ын зардлыг 21.2 сая төгрөгөөр, АЗДТГ-ын зардлыг 1.7 сая төгрөгөөр бууруулж, сумдад олгох тусгай зориулалтын шилжүүлгийн зардлыг 503.3 сая төгрөгөөр, Худалдан авах ажиллагааны албаны зардлыг 2.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 6 дугаар сарын 16-ны 02 дугаар хуралдааны 02 тоот тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын тогтоолыг орон нутагт хэрэгжүүлж төрийн үйлчилгээний зарим албан тушаалтны цалингийн шатлалын өөрчлөлт болон хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу татварын хөнгөлөлт болон буцаан олголтыг иргэдэд олгох, төсөвт байгууллагуудын төсвийн урамшууллыг журмын дагуу тооцон олгох, Засаг даргын нөөц сан, төвлөрсөн арга хэмжээний зардал, орон нутгийн хөгжлийн сан, зарим төсөвт байгууллагуудын цалин болон урсгал зардал, тусгай зориулалтын шилжүүлгийн өөрчлөлт зэрэгт тодотголыг хийжээ.

Аймгийн ИТХ-ын 12 дугаар сарын 22-ны 13 дугаар хуралдааны 03 тоот тогтоолоор “Төсвийн тухай” хуулийн 34.2.1-ийн заалт, УИХ-ын нэгдсэн чуулганы 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар баталсан “Монгол улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн дагуу тодотголыг хийсэн байна.

Ийнхүү аймгийн ИТХ-ын “Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 18.1, Төсвийн тухай хуулийн 64.1.2-т заасан аймгийн төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах, тодотгол хийх бүрэн эрхийнхээ хүрээнд хийсэн 2 удаагийн тодотгол нь “Төсвийн тухай” хуулийн 34.2.1, 34.2.2-ын заалтуудтай нийцэж байна.

Аймгийн Аудитын газар “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 заалтын бүрэн эрхийн дагуу аймгийн орон нутгийн төсвийн 2014 оны төсвийн төсөлд санал

дүгнэлт боловсруулан, аймгийн ИТХ-д дараах зарлага бууруулах саналыг оруулсан билээ. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын төлбөр хураамжийн зардалыг 2013 онд 1.0 сая төгрөгөөр батлагдсан байхад 2014 онд 61.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь үндэслэлгүй тул тухайн зардлыг 60.0 сая төгрөгөөр бууруулах.
2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь “Төсвийн тухай” хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй гэж үзсэн тул төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх үүднээс уг зардлыг шаардлага хангасан тохиолдолд төсөвт тодотгон тусгах саналыг оруулсан.

Гэвч аймгийн ИТХ-ын төлбөр хураамжийн зардлыг 46.8 сая төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтаар сумдын ЗДТГ-т автомашин авахад 465.0 сая төгрөг төлөвлөж баталсан ба аймгийн ИТХ-ын 6 дугаар сарын 16-ны 02 дугаар хуралдааны 02 тоот тогтоолоор урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр аймгийн ИТХ-ын урсгал зардлыг 144.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсний дотор ИТХ-д суудалтай намд олгох дэмжлэгийг 117.0 сая төгрөгөөр, сургалт семинар зохион байгуулах зардлыг 10.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, аудитын газраас өгсөн саналыг хэрэгжүүлээгүй байна.

2.2. Төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын харилцах дансаар дамжуулан санхүүжүүлэн гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын 2013 оны 12 дугаар сарын 04-ний хуралдаанаар Хэнтий аймгийн 2014 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө 56607,4 сая төгрөгөөр батлагдсан боловч 2014 оны 6 дугаар сарын 16-нд хийсэн тодотголоор 2716,8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2014 оны 12 дугаар сарын 22-нд хийсэн тодотголоор 310,7 сая төгрөгөөр бууруулан, 59013,4 сая төгрөгт хүргэжээ. Үүн дээр сумдын орлогоос санхүүжих 1995.1 сая төгрөгийн зардлыг нэмж тооцвол аймгийн хэмжээнд төсөвт зардлыг 61008,5 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн орлогыг авч үзвэл:

Хэнтий аймгийн 2014 оны орлогын төлөвлөгөөний биелэлт /сая.төгрөгөөр/

№	Орлогын төрөл	2013 оны гүйцэтгэл	2014 оны		Зөрүү	
			Төлөвлөгөө	гүйцэтгэл	Гүйцэтгэл 2014-2013 он	2014оны гүйц-төл
1	Татварын орлого	6285.7	7489.4	7331.5	1045.8	-157.9
2	Татварын буцаан олголт	-376.4	-505.3	-505.3	-128.9	0.0
3	Татварын бус орлого	1901.1	780.7	936.8	-964.3	156.1
4	Хөрөнгө худалдсаны орлого	396.3	330.0	204.8	-191.5	-125.2
5	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО:	44786.7	52913.6	50287.7	5501.0	-2625.9
5.1	ОНХСангийн орлогын шилжүүлэг	8262.5	10461.5	8445.6	183.1	-2015.9
5.2	Санхүүгийн дэмжлэг	9116.6	9610.6	9610.6	494.0	0.0
5.3	Тусгай зориулалтын шилжүүлэг	26030.0	30172.1	30168.5	4138.5	-3.6
5.4	Хандивын орлого	996.1	156.0	383.5	-612.6	227.5
5.5	ТЗШ-ийн өөрийн орлого	93.5	116.2	170.2	76.7	54.0
5.6	Урьд оны үлдэгдлээс	288.0	2397.2	1509.3	1221.3	-887.9
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО		52993.4	61008.4	58255.5	5262.1	-2752.9

Нийт орлого 2752.9 сая төгрөгөөр тасарсан нь ОНХС-гийн орлогын шилжүүлэг 2015.9 сая төгрөгөөр дутуу ирсэнтэй холбоотой байна.

Аймгийн Орон нутгийн төсвийн орлого 8094.8 сая төгрөгөөр \сүүлийн тодотголоор\ батлагдаж, гүйцэтгэлээр 7967.8 сая төгрөгийн орлого төвлөрч 98.4 хувиар буюу 127.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Татварын буцаан олголтыг хасч тооцвол татварын орлого 6826,2 сая төгрөгөөр биелж, төлөвлөгөөнөөс 157.9 сая төгрөгөөр тасарсан нь рашаан ус ашигласны төлбөр 317,8 сая төгрөгөөр, газрын дуудлага худалдааны орлого 68,3 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн татварын орлого 64,1 сая төгрөгөөр, хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөө 62.0 сая төгрөгөөр тасарсантай холбоотой бөгөөд рашаан ус ашигласны төлбөрийн орлого тасарсан нь Бор-Өндөрийн УБҮ-ийн борлуулалт буурсантай холбоотой байна.

Орлогыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал татварын орлого 1045.8 сая төгрөгөөр нэмэгдэж, тусгай зориулалтын шилжүүлэг 4138.5 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэг 494.0 сая төгрөгөөр, ОНХС-ийн шилжүүлэг 183.1 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс санхүүжсэн дүн 1221.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, татварын бус орлого 964.3 сая төгрөгөөр, хөрөнгө худалдсны орлого 191.5 сая төгрөгөөр, хандивын орлого 612.6 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийт орлого, зарлагын гүйцэтгэл өмнөх оны гүйцэтгэлээс 5262.1 сая төгрөгөөр өссөн байна.

2.3. Төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар

Төсвийн гүйцэтгэлээр нийт зардлыг авч үзвэл 61008,5 сая төгрөг зарцуулахаас 58255,6 сая төгрөгийг зарцуулж, 2752,9 сая төгрөгөөр буюу 4,5 хувиар хэмнэж ажиллажээ.

Нийгмийн халамжийн зардал 388,8 сая төгрөг, үүний дотор халамжийн тэтгэвэр 240,9 сая төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж 139,4 сая төгрөгөөр, жирэмсэн, хоол тэжээлийн тусламж, дэмжлэг 70,1 сая төгрөгөөр, амаржсан эхийн тэтгэмж 46,2 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Харин ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт 137,1 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Мөн төсөвт байгууллагын цалин хөлсний зардал 173,5 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний тогтмол зардал 120,4 сая төгрөгөөр, бусад зардал 315,1 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 1701,2 сая төгрөгөөр хэмнэгдсэн бөгөөд цалингийн зардлын хэмнэлт нь орон нутгийн төсөвт байгууллагуудын цалингийн сангийн хэмнэлттэй холбоотой байна.

Орон нутгийн төсвийн 58255,6 сая төгрөгийн нийт зарлагын гүйцэтгэлийн бүтцийг авч үзвэл: Нийт зарлагын 10,8 хувь буюу 6311,1 сая төгрөгийг нийгмийн халамжийн зардал, 46,7 хувь буюу 27201,3 сая төгрөгийг цалин хөлс, шимтгэлийн зардал, 5,4 хувь буюу 3176,7 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний тогтмол зардал, 12,8 хувь буюу 7487,1 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал, 20,1 хувь буюу 11719,6 сая төгрөгийг хөрөнгийн зардал эзлэж байна.

Орон нутгийн төсвийн зарлага өмнөх онд 24819.8 сая төгрөг байсан бол 2014 онд 28174.6 сая төгрөг болж 3354.8 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд орон нутгийн төсвийн байгууллагуудад 18266,6 сая төгрөгийн төсөв батлагдаж, 17436,3 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэлээр 17164,5 сая төгрөгийг зарцуулж, 321,2 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн байна. ОНХС-д 12453.6 сая төгрөгийн төсөв батлагдснаас гүйцэтгэлээр 11010.1 сая төгрөгийг зарцуулж 27.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Мөн сумдад 4979.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн ИТХ төлбөр хураамжийн зардлыг илүү төлөвлөн 25,0 сая төгрөгөөр автомашин, 2,5 сая төгрөгөөр хэлмэгдлийн хөшөө, 7,3 сая төгрөгөөр компьютер, тоног төхөөрөмж худалдан авч санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд ангилал зөрүүлэн бүртгэн, зардлын зүйл ангийг зориулалт бусаар зарцуулж “Төсвийн тухай” хуулийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Мөн Турк улсын элчин сайдын урилгаар аймгийн ИТХ-ын 35 төлөөлөгч Турк улсад айлчлахдаа 116,0 сая төгрөгийг гадаад албан томилолтын зардалд зарцуулсан нь “Төсвийн тухай” хуулийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, болон ЗГ-ын 2014 оны 05 сарын 10-ны өдөр батлагдсан “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 дугаар тогтоолын 3.5 “**Гадаад албан томилолтын зардлыг бууруулах**, зайлшгүй тохиолдолд зорчих **төлөөлөгчийн тоог цөөлөх**, төсвийн хөрөнгөөр бизнес ангиллын нислэгээр зорчихгүй байх” заалттай нийцээгүй байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 30288,3 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 30081,0 сая төгрөгийг зарцуулж 208,2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд:

Тусгай шилжүүлгийн төсвийн гүйцэтгэлийг авч үзвэл: Зардал нийт дүнгээрээ 207.3 сая төгрөгөөр хэмнэгдсний дотор хичээл үйлдвэрлэлийн зардал 30.2 сая төгрөгөөр, хоолны зардал 15,7 сая төгрөгөөр, үдийн цайны зардал 14,7 сая төгрөгөөр, ном хэвлэл худалдан авах зардал 7.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 6.8 сая төгрөгөөр, төлбөр хураамж болон урсгал засвар, эм, нормын хувцас, зөөлөн эдлэл авах, биеийн тамирын уралдаан тэмцээн, дотоод албан томилолтын 4.5-2.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Мөн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын нэмэлт дансны үлдэгдэл 182,2 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн. Тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалт өмнөх оны гүйцэтгэлээс 3931.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хэнтий аймагт 2014 онд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгт 9610.6 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлгээр 8445.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Тусгай зориулалтын шилжүүлгээр 30168.5 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нийт 1970357.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл: Төсөл санд 763430.0 мянган төгрөгийн, төрийн санд 1064554.2 мянган төгрөгийн, төсөвт байгууллагад 29940.8 мянган төгрөгийн, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид 11243.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт 758.1 сая төгрөгийн богино хугацаат өглөгийн 465.6 сая төгрөг буюу 61.4 хувь нь ОНӨҮГ-ын, 70.0 сая төгрөг буюу 9.2 хувь нь төсөвт байгууллагын, 40.2 сая төгрөг буюу 5.3 хувь нь төсөл сангийн өглөг байна.

2040.2 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2004 оноос 9 аймагт Нийтийн ахуй үйлчилгээний ажлыг сайжруулах дэмжих зорилгоор олгогдсон төслийн зээлийн өглөг байна.

Орон нутагт 2014 онд Хүний хөгжил сангийн санхүүжилт, орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй, хаагдсан байна.

2.4 Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн талаар :

Сангийн эх үүсвэрт нийт 16807,1 сая төгрөгийн орлого төвлөрөхөөс 13645.0 сая төгрөгийн орлого төвлөрч 3162.1 сая төгрөгөөр тасарсан байна. Үүнд төсөвт газраас төлөх

шимтгэл 1468.8 сая төгрөгөөр, ажиллагсдаас төлсөн шимтгэл 2623.0 сая төгрөгөөр тасарсан нь төлөвлөлттэй холбоотой байна.

Нийт 29589.7 сая төгрөгийг зарцуулахаас 29381.9 сая төгрөгийг зарцуулж 207.8 сая төгрөг хэмнэсэн байна. Тэтгэврийн даатгалын санд 21856.8 сая төгрөг зарцуулахаас 22260.8 сая төгрөг зарцуулж 404.0 сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын санд 188.4 сая төгрөг зарцуулахаас 240.4 сая төгрөг зарцуулж 51.9 сая төгрөгөөр хэтэрч, ҮОМШӨ-ийн даатгал, ЭМД, тэтгэмжийн даатгалын орлого давж биелэсэн байна.

Гурав. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

2015 онд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн судалгааг ТЭЗ-ийн хүрээнд 1, ТТЗ-ийн хүрээнд 22, ТШЗ-ийн хүрээнд 215, ТБОНӨ хуулийн этгээдийн 9 байгууллага буюу нийт 247 байгууллагад байршуулбал зохих мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудас, байгууллагын цахим хуудсанд хэрхэн байршуулсаныг хянан үзэж гаргалаа.

Судалгаагаар 247 байгууллагаас нэгдсэн цахим хуудсанд 15.8 хувь буюу 38 байгууллага мэдээллийг байршуулаагүй, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журмын 4.1, 7.2-ын заалтыг зөрчсөн байна. Үүнд: Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Баянмөнх, Баян-Овоо, Баянмөнх, Баянхутаг, Норовлин сумын ТЭЗ болон Гурван баян, Өлзийт, ХБУ-н тосгоны Захирагч, ЗХ-ний 232-р анги, Улсын Нөөцийн Хэнтий салбар, Онон голын сав газар, Баянхутаг сумын ЗДТГ, БЗД, Баянмөнх сумын ИТХ, ЗДТГ, БЗД, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Дархан сумын БЗД, ХБУ тосгоны Цэцэрлэг, ЭМТ, Цэнхэрмандал сумын ИТХ, Баян-Овоо сумын ИТХ, Гурван баян тосгоны ЗАА, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв, Норовлин сумын БЗД, Тахилгат тосгоны ЗАА, Аймгийн Номын сан, Хэрлэн сумын “Ач манал”, “Оюуны шим”, “Хэрлэн дом” өрхийн эмнэлгийн зэрэг төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч нар шилэн дансны хууль, журмыг хэрэгжүүлээгүй байна.

Нэгдсэн цахим хуудсанд 2 байгууллага байршуулбал зохих мэдээллээс 5 мэдээллийг оруулсан бол, 21 байгууллага 3-4 мэдээллийг оруулж, 185 байгууллага буюу 75 хувь нь 1-2 мэдээллийг оруулжээ.

Мэдээллийг шивсэн бүх байгууллагууд батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийг нийтлэг оруулж, 9 байгууллага 5 саяас дээш үнэ бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилт, хэмжээ, нийлүүлэгчийн хаягийг оруулсан байна.

Байгууллагын цахим хуудсанд төсөв, санхүүгийн талаарх мэдээллээ 247 байгууллагаас 15 орчим хувь нь байршуулсан байна. “Хэнтий-Ус” ХХК мэдээллийг байршуулахад бааз үүсэхгүй, шивэхэд алдаа гарч, холбогдогдох хүмүүстэй ярьсан ч мэдээллийг байршуулж чадаагүй байгаа тайлбаруудыг өгсөн болно.

Аймгийн Аудитын газар төсвийн зарцуулалтын мэдээллээ нэгдсэн цахимд огт байршуулаагүй, шилэн дансны хуулийг зөрчсөн байгууллагын дарга нарт шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах тухай албан бичиг хүргүүлсэн боловч ХБУлаан тосгоны Цэцэрлэг, Ач манал, Оюуны шим, Хэрлэн дом өрхийн эмнэлгүүд нь одоог хүртэл мэдээллээ оруулаагүй -Шилэн дансны тухай- хуулийг зөрчиж байна.

Дөрөв. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2013 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга С.Пүрэвжав –т:

1. Аймгийн ИТХ-ын 2012 оны 12-р сарын 9-ны өдрийн Хоёрдугаар хуралдааны 01 дугаар тогтоол, мөн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 01 дүгээр сарын 24-ний 12 дугаар тогтоолд аймгийн орон нутгийн төсвийг алдагдалтай байхаар тусгасан нь Төсвийн тухай хуулийн 57.2-ын “Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж,

хэрэгжүүлнэ” гэсэн заалт зөрчигдөхөд хүргэж байгаа тул цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар анхаарч ажиллан, тогтоолд дурьдсан тооцоо, тооцоололд тавих хяналтыг сайжруулах

2. Аймгийн орон нутгийн төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах аймгийн ЗД-ын төсвийн төслийг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн баталдаг зөрчлийг арилгаж, ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлаж байх гэсэн 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж 2014 онд ИТХ-аар 2 удаагийн төсвийн тодотголыг хэлэлцүүлэн баталсан байна.

Аймгийн Засаг дарга Ж.Оюунбаатар -г:

1. Төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн урсгал зардлыг хэмнэх, үр ашиггүй зардлыг төсөвт тусгахгүй байх замаар зарлагын тэлэлтийг багасгаж ажиллах. Үүнд: Батлагдсан орон тоог баримтлах, урсгал зардлыг хэмнэж ажиллах,
2. Аймгийн ТЭЗ-ийн төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж ИТХ-д өргөн мэдүүлэхдээ “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн 7.3-ын “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэсэн заалтыг баримталж ажиллах
3. Аймгийн орон нутгийн төсвийн төслийг бодитой, үнэн зөв, тооцоо судалгаанд тулгуурлан боловсруулж байх.
4. Аймгийн Боловсролын салбарын ажиллагсдын цалингийн зардлыг бодитой, үнэн зөв төлөвлөх, санхүүжилтийг зөв хуваарилах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах гэсэн 4 зөвлөмжөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж урсгал зардлыг хэмнэх, үр ашиггүй зардлыг төсөвт тусгахгүй байх замаар зарлагын тэлэлтийг багасгаж ажиллах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Тав. Дүгнэлт

1. Орон нутгийн төсвийн тодотголыг “Төсвийн тухай” хуулийн дагуу хийжээ.
2. Гэвч аймгийн ИТХ төсвийг тодотгохдоо “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2014 оны 05 сарын 10–ны өдрийн 147 дугаар тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Зургаа. Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга С.Пүрэвжав, аймгийн Засаг дарга Ж.Оюунбаатар нарт:

1. Цаашид төсвийн зарлагыг төлөвлөж, батлахдаа Төсвийн тухай хуулийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалт болон ЗГ-ын 2014 оны 05 сарын 10–ны өдөр батлагдсан “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 дугаар тогтоолыг мөрдөн ажиллах.

Долоо. Холбогдох байгууллагын санал



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Утас/Факс: 70-55-24-12
E-mail: khentiaudit@yahoo.com

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬЯА ХЭНТИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

№ _____

тандай 2015.05.19 -ны № 83 -т

Тайлангийн төслийн талаар

"Хэнтий аймгийн 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүлээн авч танилцлаа. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно. Тайлангийн төслийн талаар дараах саналтай байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-аас ирүүлсэн Турк улсын элчин сайдын урилгаар аймгийн ИТХ-ын 35 төлөөлөгч Турк улсад айлчлах болсон тул 117,0 сая төгрөг шаардлагатай гэсэн саналын дагуу ИТХ-д суудалтай нэмд олгох зардлыг тодотголоор нэмэгдүүлэн ИТХ-аар баталсан. Энэ айлчлалын үр дүнд гадаад харилцаа өргөжиж, Туркийн Засгийн газрын 100 хувийн тэтгэлгээр оюутан суралцуулах, орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд хөрөнгө оруулах зэрэг үр дүнтэй ажил болсон гэж үзэж байна.
2. Засгийн газрын 147 дугаар тогтоолыг тодорхой хэмжээгээр хэрэгжүүлсний үр дүнд орон нутгийн төсвийн байгууллагын зардлын хэмнэлт 321.2 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын зардлын хэмнэлт 208,2 сая төгрөгийг санхүүжилт авсан эх үүсвэрийн дансанд тус тус төвлөрүүлсэн болно.
3. 2014, 2015 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг аймгийн ИТХ-нд шууд оруулж байсан. Иймээс цаашид төсвийн төсөлд хийсэн аудитын талаар хуралд оруулахаас өмнө аймгийн Засаг даргад урьдчилан танилцуулж, зөвлөмж ирүүлж байвал зүйтэй байна.



САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА _____ С.ХЭРЛЭНЧИМЭГ

09 875

Саналд өгөх төрийн аудитын байгууллагын тайлбар:

1. Турк улсад хийсэн айлчлал нь аймаг орон нутгийн хөгжилд үр дүнгээ өгсөн ажил болсон ч төлөөлөгчийн бүрэлдэхүүнийг батлахдаа төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулах зарчмыг баримтлаагүй.

2. Төсвийн байгууллагын зардлын хэмнэлтийн үлдэгдлийг төвлөрүүлсэн талаар тайлангийн 2.3 хэсэгт тусгасан болно.

3. Саналыг хүлээн авлаа. Аймгийн СТС-ийн хэлтэс нь төсвийн төслийг Төрийн аудитын байгууллагад санал дүгнэлт гаргуулахаар аймгийн ИТХ-ын хугацааг тулгаж ирүүлж байснаас манай санал дүгнэлттэй аймгийн ИТХ-ын төлөөлөгчид танилцах боломжгүй байсан. Цаашид "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 7.3-д заасан хугацаанд аудитын байгууллагад төсвийн төслийг ирүүлвэл мөн журмын 7.4-д заасан хугацаанд аймгийн ИТХ-д саналыг хүргүүлэх боломжтой.

Найм. Хавсралтууд

Хэнтий аймгийн Төсвийн орлогын судалгаа

Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангийн судалгаа

Хэнтий аймгийн Тусгай шилжүүлгийн нэгтгэсэн тайлангийн зарлагын судалгаа

Тайлан бичсэн: Ахлах аудитор

Н.Туяа

Аудитор

Ү.Төгсжаргал